

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	2
2.1	Оршил.....	2
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	2
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	3
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	3
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	4
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	5
2.9	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	6
2.10	ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААР.....	6
2.11	Шилэн дансны мэдээлэл.....	7
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3	Менежментийн захидал.....	8
3.1	Тооллогын талаар.....	8
3.2	Баримтжуулалтын талаар.....	9
3.3	Төсвийн зарцуулалтын талаар.....	9
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	13
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан..... Error! Bookmark not defined.	
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2019.03.04 № 06/380
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заасны дагуу Геронтологийн үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Геронтологийн үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Геронтологийн үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Геронтологийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус хүрээлэнгийн захирал Р.Хишигжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Геронтологийн үндэсний төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Геронтологийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 1-нээс 2019 оны 2 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Ниямазон аудит” ХХК-ийн аудитор Т.Оюун хариуцаж хэрэгжүүлэв.

Геронтологийн үндэсний төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 28 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат, шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Геронтологийн үндэсний төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Геронтологийн үндэсний төвийн үйл ажиллагааны зорилгыг Монгол хүний насжилт түүнд нөлөөлөх хүчин зүйлийг судалж, ахмад настанд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн арга зүйгээр хангах сургалт, сурталчилгаа явуулахад оршино гэж тодорхойлсон.

Эрүүл мэндийн сайдын 2013 оны 226 дугаар тушаалаар тус төвийн үйл ажиллагааны чиглэлийг баталсан байна. Үүнд:

Монгол хүний насжилтын байдал түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах үйл ажиллагааг явуулах

Нотолгоонд тулгуурласан геронтологи болон гериатрийн тусламжийг настан хүн амд үзүүлж, настанд нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээг хөгжүүлэх;

Эрүүл насжилтыг дэмжих олон талт үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулах, удирдан чиглүүлэх, олон улсын болон дотоодын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;

Геронтологи болон гериатрийн чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй эрүүл мэндийн болон бусад байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хяналт үнэлгээ хийн лавлагаа тусламж үзүүлэх;

Насжилт, настны эмгэг судлалын чиглэлээр эрүүл мэндийн мэргэжилтэн, бусад мэргэжилтэнд төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт, хүн амын зорилтот бүлэг, настанд зориулсан сургалтыг зохион байгуулах;

Геронтологийн үндэсний төвийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Геронтологийн үндэсний төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Аудитын явцад төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус хүрээлэнгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Геронтологийн үндэсний төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлж, мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Геронтологийн үндэсний төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" програм хангамжийг ашиглаж байна.

Геронтологийн үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтын ажилтангүй байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Геронтологийн үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 6 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 6 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонголоо.

Геронтологийн үндэсний төвийн 2018 оны нийт зардал 683,738.7 мянган төгрөгийн 1 хувь болох 683.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	19,928.6	
	Дүн	3	19,928.6	

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Геронтологийн үндэсний төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 612,821.9 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 612,776.8 мянган төгрөг зарцуулжээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Тус байгууллага 2018 онд 13,000.0 мянган төгрөгийн орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, улсын төсвөөс 362,710.6 мянган төгрөгийн, эрүүл мэндийн даатгалын сангаас 237,066.6 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус авсан байна.

2.10 Үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний талаар

Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын дагуу газар, барилга байгууламжийн дахин үнэлгээг санхүүгийн тайлагналын зорилгоор хийж, үнэлгээний нягтлан шалгалтыг мэргэшсэн үнэлгээчин Б.Бурмаагаар хийлгүүлсэн байна.

Сүхбаатар дүүргийн 11 дүгээр хороо, Цагдаагийн гудамжинд байрлах 1816 м.кв газрыг 58,802.1 мянган төгрөгөөр үнэлж, бусад биет бус хөрөнгө болон Засгийн газрын хувь оролцоог нэмэгдүүлсэн;

Геронтологийн үндэсний төвийн барилга нь 725,088.0 мянган төгрөгийн анхны үнэтэй, өртгөө нөхсөн барилгыг 94,574.0 мянган төгрөгөөр үнэлж, барилга байгууламжийн данс болон дахин үнэлгээний нэмэгдэл дансыг нэмэгдүүлсэн;

Бүртгэлд тусгаагүй байсан дулааны болон бохирын шугам, авто зогсоолыг 10,735.8 мянган төгрөгөөр үнэлж, барилга байгууламж данс болон орлогын дансыг нэмэгдүүлсэн бичилтийг тус тус хийсэн байна.

2.11 Шилэн дансны мэдээлэл

Геронтологийн үндэсний төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тайлант онд нийт 146 мэдээллийг шилэн дансанд оруулсан байна.

Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын үйл ажиллагааны онцлог, эрх зүйн өөрчлөлтийг тусган шинэчлэх, санхүүгийн програмыг сайжруулах зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Геронтологийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБООС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Геронтологийн үндэсний төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНБООС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Геронтологийн үндэсний төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Тооллогын талаар

3.1.1. Илрүүлэлт:

2018 оны жилийн эцсийн тооллогыг комиссын гишүүд нэр төдий хийсэн, тооллогын тайланг зохих ёсоор бэлтгээгүй, гарын үсгээр баталгаажуулаагүй, тооллого бодитоор хийснийг нотлох баримт хангалтгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-д “тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг ... үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, 72.4.4-т “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ... тусгай жагсаалтаар шилжүүлэн өгнө”

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.2. Эрсдэл:

Үнэн зөв байдал-Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, тооллогыг зохих ёсоор нь хийж хэвших, баримтжуулалтыг чанартай хийх зөвлөмж хүргүүлэх

3.1.4. Төсөв захирагчийн хариу:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлж ажиллана.

3.2 БАРИМТЖУУЛАЛТЫН ТАЛААР

3.2.1. Илрүүлэлт:

Тус төвийн харилцах дансны баримтыг шалгаж үзэхэд тайлант онд 18,753.9 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээнд төлбөрийн и-баримт аваагүй байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “бараа, ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”,

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн, нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-т “төлбөрийн баримт нь бараа, ажил үйлчилгээний төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Үнэн зөв байдал-Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Бараа, ажил үйлчилгээ худалдан авах бүрт нийлүүлэгчээс төлбөрийн и-баримтыг шаардан авч байх

3.2.4. Төсөв захирагчийн хариу:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлж ажиллана.

3.3 ТӨСВИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР

3.3.1. Илрүүлэлт:

Геронтологийн үндэсний төвийн захирлын 2018 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар тус төвийн ажилтнуудын дунд зохион байгуулсан "Хөдөлгөөн эрүүл мэнд-IV" спортын тэмцээнд амжилттай оролцсон 14 ажилтанд 1,174.7 мянган төгрөгийн урамшууллыг цалингийн сангаас гаргахаар шийдвэрлэн олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “төсвийн шууд захирагч ... батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

3.3.2. Эрсдэл:

Үнэн зөв байдал-Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

3.3.3. Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

3.3.4. Төсөв захирагчийн хариу:

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Геронтологийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>69 601 138,29</u>	<u>123 150 260,79</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	500 000,00	500 000,00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	500 000,00	500 000,00
31110	Төгрөг	500 000,00	500 000,00
33	АВЛАГА	0,00	22 392 605,10
335	Бусад авлага	0,00	22 392 605,10
3351	Байгууллагаас авах авлага		22 392 605,10
35	БАРАА МАТЕРИАЛ	69 101 138,29	100 257 655,69
351	Түүхий эд материал	5 948 636,76	14 168 218,49
35110	Тусгай зориулалттай материал	80 000,00	80 000,00
35130	Эм боох материал	5 868 636,76	14 088 218,49
35300	Бэлэн бүтээгдэхүүн	6 991 620,00	8 315 120,00
354	Хангамжийн материал	56 160 881,53	77 774 317,20
35410	Бичиг хэргийн материал	436 255,00	1 902 840,00
35420	Аж ахуйн материал	1 520 988,00	638 801,00
35430	Сэлбэг хэрэгсэл	1 972 050,00	92 050,00
35440	Түлш, шатах тослох материал	492 521,73	688 277,40
35470	Бусад хангамжийн материал	51 739 066,80	74 452 348,80
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2 250 353 253,39</u>	<u>401 714 329,38</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2 250 353 253,39	401 714 329,38
392	Биет хөрөнгө	2 250 272 586,56	342 912 249,38
39201	Барилга, байгууламж, орон сууц	725 088 000,00	125 920 677,50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-725 088 000,00	-20 610 810,00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	64 836 549,00	94 536 549,00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-34 953 911,65	-42 894 313,57
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	569 183 532,05	351 403 769,05
39206	Хуримтлагдсан элэгдэл	-358 786 742,96	-176 304 282,00
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25 719 467,00	26 111 970,00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-16 939 453,88	-16 753 880,60
39216	Дуусаагүй барилга, байгууламж	1 999 988 447,00	
39217	Ном	1 224 700,00	1 502 570,00
393	Биет бус хөрөнгө	80 666,83	58 802 080,00
39301	Програм хангамж	1 470 000,00	1 470 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1 389 333,17	-1 470 000,00
39303	Бусад биет бус хөрөнгө		58 802 080,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2 319 954 391,68</u>	<u>524 864 590,17</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>177 140,40</u>	<u>0,00</u>
413	Өглөг	177 140,40	0,00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	177 140,40	

Геронтологийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2 319 777 251,28</u>	<u>524 864 590,17</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2 319 777 251,28	524 864 590,17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2 420 089 675,00	478 903 308,00
51101	Өмч: - төрийн	2 420 089 675,00	478 903 308,00
512	Хуримтлагдсан үр дүн	-135 236 737,39	-83 537 021,50
51210	Өмнөх үеийн үр дүн	-129 615 828,25	-135 236 737,39
51220	Тайлант үеийн үр дүн	-5 620 909,14	40 963 838,39
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	34 924 313,67	129 498 303,67
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2 319 954 391,68</u>	<u>524 864 590,17</u>

Геронтологийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	622 161 415,00	735 438 402,60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	18 880 404,00	53 545 897,50
120	Нийтлэг татварын бус орлого	13 721 404,00	23 845 897,50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13 000 000,00	23 735 477,50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13 000 000,00	12 999 600,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		10 735 877,50
120009	Бусад орлого	721 404,00	110 420,00
122	Тусламжийн орлого	5 159 000,00	29 700 000,00
122001	Хандив тусламж /дотоод/	5 159 000,00	29 700 000,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	603 281 011,00	681 892 505,10
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	426 584 100,00	362 754 700,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	426 584 100,00	362 754 700,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8 716 911,00	82 071 205,10
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		3 200 000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8 716 911,00	78 871 205,10
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	167 980 000,00	237 066 600,00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	167 980 000,00	237 066 600,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	627 782 324,14	683 738 686,70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	610 252 215,17	661 443 956,16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	610 252 215,17	661 443 956,16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406 772 822,67	422 095 821,24
210101	Үндсэн цалин	384 592 831,67	346 548 020,44
210102	Нэмэгдэл	2 668 708,00	1 824 733,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12 632 500,00	44 310 427,00
210104	Урамшуулал	6 878 783,00	29 412 640,80
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	45 351 531,02	51 622 162,35
210201	Тэтгэврийн даатгал	29 174 995,43	35 264 440,29
210202	Тэтгэмжийн даатгал	3 833 864,13	4 159 228,23
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 367 061,14	3 369 740,81
210204	Ажилгүйдлийн даатгал	988 882,68	859 501,60
210205	Эрүүл мэндийн даатгал	7 986 727,64	7 969 251,42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12 528 734,60	12 963 533,00
210301	Гэрэл, цахилгаан	4 752 564,60	5 679 600,00
210302	Түлш, халаалт	2 186 763,00	3 070 833,00
210303	Цэвэр, бохир ус	1 989 407,00	2 773 100,00
210304	Байрны түрээс	3 600 000,00	1 440 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	19 789 252,21	32 405 969,79
210401	Бичиг хэрэг	5 449 645,00	5 850 015,00

Геронтологийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210402	Тээвэр, шатахуун	5 029 215,97	5 704 344,33
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 258 672,24	2 746 164,46
210404	Ном, хэвлэл		6 348 500,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5 107 054,00	5 762 137,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2 944 665,00	5 994 809,00
2105	Нормативт зардал	23 034 668,44	11 600 896,27
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	23 025 668,44	11 600 896,27
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9 000,00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18 245 040,00	15 883 750,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	140 000	
210602	Тавилга		30 000
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1 842 370,00	38 250,00
210604	Урсгал засвар	16 262 670,00	15 815 500,00
2107	Томиллот, зочны зардал	14 807 311,00	15 010 500,00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт	14 807 311,00	15 010 500,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6 321 790,90	8 336 296,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2 039 400,00	1 980 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	65 340,00	63 500,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	152 000,00	206 600,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	21 000,00	30 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3 067 029,90	4 623 966,00
210807	Газрын төлбөр	158 200,00	194 800,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	818 821,00	1 237 430,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	63 401 064,33	91 525 027,51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17 776 240,00	34 993 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	802 960,00	645 696,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44 821 864,33	55 886 331,51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17 530 108,97	22 294 730,54
2132	Бусад урсгал шилжүүлэг	14 581 000,00	22 250 663,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		15 608 200,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14 581 000,00	6 642 463,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2 949 108,97	44 067,54
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2 949 108,97	44 067,54
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>-5 620 909,14</u>	<u>51 699 715,90</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>-5 620 909,14</u>	<u>51 699 715,90</u>

Геронтологийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	616 281 011,00	694 892 105,10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13 000 000,00	12 999 600,00
120	Нийтлэг татварын бус орлого	13 000 000,00	12 999 600,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	13 000 000,00	12 999 600,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13 000 000,00	12 999 600,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	603 281 011,00	681 892 505,10
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	426 584 100,00	362 754 700,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	426 584 100,00	362 754 700,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	8 716 911,00	82 071 205,10
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		3 200 000,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8 716 911,00	78 871 205,10
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	167 980 000,00	237 066 600,00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	167 980 000,00	237 066 600,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	593 198 151,00	682 589 348,10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	593 198 151,00	682 589 348,10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	575 539 042,03	637 902 012,46
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	406 386 999,29	422 947 100,00
210101	Үндсэн цалин	334 149 699,29	353 937 700,00
210102	Нэмэгдэл	13 154 000,00	9 290 100,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31 787 900,00	31 787 900,00
210104	Урамшуулал	27 295 400,00	27 931 400,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44 711 200,00	50 753 700,00
210201	Тэтгэврийн даатгал	37 386 456,00	33 835 800,00
210202	Тэтгэмжийн даатгал	1 542 052,00	4 229 500,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 927 564,00	3 383 600,00
210204	Ажилгүйдлийн даатгал		845 900,00
210205	Эрүүл мэндийн даатгал	3 855 128,00	8 458 900,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12 528 734,60	12 963 533,00
210301	Гэрэл, цахилгаан	4 752 564,60	5 679 600,00
210302	Түлш, халаалт	2 186 763,00	3 070 833,00
210303	Цэвэр, бохир ус	1 989 407,00	2 773 100,00
210304	Байрны түрээс	3 600 000,00	1 440 000,00
2104	Хангамж, бараа материалын зардал	19 687 256,24	44 520 500,20
210401	Бичиг хэрэг	1 628 900,00	6 024 400,00
210402	Тээвэр, шатахуун	5 501 500,00	5 900 100,00

Геронтологийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 253 672,24	2 733 000,20
210404	Ном, хэвлэл		21 139 100,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3 678 212,00	2 603 900,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7 624 972,00	6 120 000,00
2105	Нормативт зардал	33 319 565,00	28 329 000,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	25 573 565,00	20 444 200,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7 746 000,00	7 884 800,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17 795 940,00	18 793 550,00
210601	Багаж, техник, хэрэгсэл	139 800,00	257 500,00
210602	Тавилга		2 291 150,00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4 501 970,00	2 422 900,00
210604	Урсгал засвар	13 154 170,00	13 822 000,00
2107	Томилот, зочны зардал	14 807 311,00	15 010 500,00
210702	Дотоод албан томилолт	14 807 311,00	15 010 500,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7 722 835,90	8 861 529,26
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2 039 400,00	1 980 000,00
210803	Даатгалын үйлчилгээ	65 340,00	63 500,00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	152 000,00	206 600,00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	21 000,00	30 000,00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3 067 029,90	4 748 099,26
210807	Газрын төлбөр	158 200,00	194 800,00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2 219 866,00	1 638 530,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18 579 200,00	35 722 600,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	17 667 200,00	34 993 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	912 000,00	729 600,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17 659 108,97	44 687 335,64
2132	Бусад урсгал шилжүүлэг	14 710 000,00	22 250 663,00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		15 608 200,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	14 710 000,00	6 642 463,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2 949 108,97	22 436 672,64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2 949 108,97	22 436 672,64
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>23 082 860,00</u>	<u>12 302 757,00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	23 082 860,00	12 302 757,00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23 082 860,00	12 302 757,00
2200	Дотоод эх үүсвэрээр	23 082 860,00	12 302 757,00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23 082 860,00	12 302 757,00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-23 082 860,00</u>	<u>-12 302 757,00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	500 000,00	500 000,00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	500 000,00	500 000,00

Геронтологийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2 420 089 675,00	34 924 313,67	-129 615 828,25	2 325 398 160,42
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2 420 089 675,00	34 924 313,67	-129 615 828,25	2 325 398 160,42
C07	Тайлант үеийн үр дүн			-5 620 909,14	-5 620 909,14
C08	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2 420 089 675,00	34 924 313,67	-135 236 737,39	2 319 777 251,28
D01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2 420 089 675,00	34 924 313,67	-135 236 737,39	2 319 777 251,28
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2 420 089 675,00	34 924 313,67	-135 236 737,39	2 319 777 251,28
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	58 802 080,00	94 573 990,00	10 735 877,50	164 111 947,50
D08	Тайлант үеийн үр дүн	-1 999 988 447,00		40 963 838,39	-1 959 024 608,61
D09	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	478 903 308,00	129 498 303,67	-83 537 021,50	524 864 590,17

Геронтологийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		500 000,00		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	612 821 900,00	612 776 832,46	45 067,54	99,5%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	612 821 900,00	612 776 832,46	45 067,54	99,5%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	597 213 700,00	597 168 632,46	45 067,54	99,5%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	422 947 100,00	422 947 100,00	-	100,0%
210101	Үндсэн цалин	353 937 700,00	353 937 700,00	-	100,0%
210102	Нэмэгдэл	9 290 100,00	9 290 100,00	-	100,0%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31 787 900,00	31 787 900,00	-	100,0%
210104	Урамшуулал	27 931 400,00	27 931 400,00	-	100,0%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50 753 700,00	50 753 700,00	-	100,0%
210201	Тэтгэврийн даатгал	33 835 800,00	33 835 800,00	-	100,0%
210202	Тэтгэмжийн даатгал	4 229 500,00	4 229 500,00	-	100,0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3 383 600,00	3 383 600,00	-	100,0%
210204	Ажилгүйдлийн даатгал	845 900,00	845 900,00	-	100,0%
210205	Эрүүл мэндийн даатгал	8 458 900,00	8 458 900,00	-	100,0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12 963 600,00	12 963 533,00	67,00	99,9%
210301	Гэрэл, цахилгаан	5 679 600,00	5 679 600,00	-	100,0%
210302	Түлш, халаалт	3 070 900,00	3 070 833,00	67,00	99,9%
210303	Цэвэр, бохир ус	2 773 100,00	2 773 100,00	-	100,0%
210304	Байрны түрээс	1 440 000,00	1 440 000,00	-	100,0%
2104	Хангамж, бараа материалын зардал	19 292 900,00	19 292 900,20	-0,20	100,1%
210401	Бичиг хэрэг	3 435 900,00	3 435 900,00	0,00	100,0%
210402	Тээвэр, шатахуун	5 900 100,00	5 900 100,00	0,00	100,0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 233 000,00	1 233 000,20	-0,20	100,1%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2 603 900,00	2 603 900,00	-	100,0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6 120 000,00	6 120 000,00	-	100,0%
2105	Нормативт зардал	28 329 000,00	28 329 000,00	-	100,0%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20 444 200,00	20 444 200,00	-	100,0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7 884 800,00	7 884 800,00	-	100,0%

Геронтологийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	23 709 500,00	23 709 500,00	-	100,0%
210601	Багаж, техник, хэрэгсэл	3 663 000,00	3 663 000,00	-	100,0%
210602	Тавилга	3 801 600,00	3 801 600,00	-	100,0%
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2 422 900,00	2 422 900,00	-	100,0%
210604	Урсгал засвар	13 822 000,00	13 822 000,00	-	100,0%
2107	Томилолт, зочны зардал	14 240 500,00	14 240 500,00	-	100,0%
210702	Дотоод албан томилолт	14 240 500,00	14 240 500,00	-	100,0%
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах			-	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9 184 400,00	9 139 399,26	45 000,74	99,9%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2 025 000,00	1 980 000,00	45 000,00	98%
210803	Даатгалын үйлчилгээ	63 500,00	63 500,00	-	100%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	206 600,00	206 600,00	-	100%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	30 000,00	30 000,00	-	100%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4 748 100,00	4 748 099,26	0,74	99,9%
210807	Газрын төлбөр	194 800,00	194 800,00	-	100%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1 916 400,00	1 916 400,00	-	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15 793 000,00	15 793 000,00	-	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15 793 000,00	15 793 000,00	-	100%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15 608 200,00	15 608 200,00	-	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	15 608 200,00	15 608 200,00	-	100%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15 608 200,00	15 608 200,00	-	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	612 821 900,00	612 776 832,46	45 067,54	99,9%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	362 754 700,00	362 710 632,46	44 067,54	99,9%
131001	Улсын төсвөөс санхүүжих	362 754 700,00	362 710 632,46	44 067,54	99,9%
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	237 067 200,00	237 066 600,00	600,00	100%
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	237 067 200,00	237 066 600,00	600,00	99,9%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	13 000 000,00	12 999 600,00	400,00	99,9%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	13 000 000,00	12 999 600,00	400,00	99,9%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн		500 000,00	-500 000,00	

Геронтологийн үндэсний төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		500 000,00	-500 000,00	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	52	45	7	87%
620001	Удирдах ажилтан	1	1	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	41	36	5	88%
620003	Үйлчлэх ажилтан	10	8	2	80%

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Геронтологийн үндэсний төвийн оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийх санхүүгийн аудитын төлөвлөгөө	Аудитын код:
2019.02.25			САГ-2019/390/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Геронтологийн үндэсний төв		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	2018 оны жилийн эцсийн тооллогыг комиссын гишүүд нэр төдий хийсэн, тооллогын тайланг зохих ёсоор бэлтгээгүй, гарын үсгээр баталгаажуулаагүй, бодитоор хийснийг нотлох баримт хангалтгүй байна.		зөвлөмж өгөх	Ерөнхий захирал	Р.Хишигжаргал
				Нягтлан бодогч	Д.Гунгаажав
2	Тус төв тайлант онд 18,753.9 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээнд төлбөрийн и-баримт аваагүй байна	18,753.9	зөвлөмж өгөх	Ерөнхий захирал	Р.Хишигжаргал
				Нягтлан бодогч	Д.Гунгаажав
3	Геронтологийн үндэсний төвийн захирлын 2018 оны 5 дугаар сарын 27-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар тус төвийн ажилтнуудын дунд зохион байгуулсан "Хөдөлгөөн эрүүл мэнд-IV" спортын тэмцээнд амжилттай оролцсон 14 ажилтанд 1,174.7 сая төгрөгийн урамшууллыг цалингийн сангаас олгосон байна.	1,174.7	зөвлөмж өгөх	Ерөнхий захирал	Р.Хишигжаргал
				Нягтлан бодогч	Д.Гунгаажав
Дүн		19,928.6			